



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 0434

Баян-Өндөр сум

Уулын дугуйн насанд хүрэгчдийн
аймгийн аварга шалгаруулах тэмцээнд
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уулын дугуйн насанд хүрэгчдийн аймагын аварга шалгаруулах тэмцээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), спортын тэмцээн, наадмын бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн (Д.Дашбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тэмцээнд зарцуулагдах 800,000 (найман зуун мянга) төгрөгийг зохих журмын дагуу үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн
10434 дугаар тушаалын хавсралт

УУЛЫН ДУГУЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Спортын төрлийн нэр	Шагналын зардал			Шүүгчийн зардал				Бүгд (төгрөгөөр)
		Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Дүн	Ажиллах хүний тоо	Өдөр	Нэг бүрийн үнэ	Дүн	
1	Уулын дугуй	I байр 2 хүн	60,000	120,000	5	1	100,000	500,000	
		II байр 2 хүн	50,000	100,000					
		III байр 2 хүн	40,000	80,000					
		Дүн		300,000				500,000	800,000
		Төсвийн нийт дүн							800,000